

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/457/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Улаанбаатар хот 2025 он	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г жорлус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/216
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН
ГАЗРЫН ДАРГА
М.БОЛДБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Татварын багц хуулийг таниулах сургалт зохион байгуулахад 24,480.0 мянган төгрөг, сурталчилгаанд 69,110.0 мянган төгрөг, видео хийхэд 8,000.0 мянган төгрөгийг 17 удаагийн үйл ажиллагаанд тус тус зарцуулсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/435 дугаар захирамжаар 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн, 2024 оны татвар хураалтад идэвх зүтгэлтэй ажилласан Нийслэл, дүүргийн ажилтнуудад 175,977.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 97.6 хувиар үнэлүүлсэн байна.

Мөн улс, орон нутгийн төсөвт 1,636,179,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,449,346,400.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 88.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	226,693,306.88	132,553,881.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	5,000,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	5,000,000.00
3122	Гадаад валют	0.00	5,000,000.00
31221	Төрийн сангийн харилцах	0.00	5,000,000.00
33	АВЛАГА	135,378,103.07	19,581,563.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	516,706.12	0.00
335	Бусад авлага	134,861,396.95	19,581,563.53
3351	Байгууллагаас авах авлага	134,333,888.08	17,776,707.66
3352	Хувь хүмүүсээс авах авлага	527,508.87	1,804,855.87
35	БАРАА МАТЕРИАЛ	91,315,203.81	107,972,317.76
354	Хангамжийн материал	91,315,203.81	107,972,317.76
35410	Бичиг хэргийн материал	6,893,478.76	17,797,232.71
35420	Аж ахуйн материал	68,884,792.00	64,346,794.00
35440	Түлш, шатах тослох материал	3,070,000.00	7,440,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,466,933.05	18,388,291.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	802,525,853.75	736,630,702.64
392	Биет хөрөнгө	754,473,933.75	688,578,782.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	622,409,666.76	622,409,666.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-74,688,660.12	-84,906,146.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,833,260.00	37,833,260.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,986,780.30	-19,813,229.62
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	421,692,255.16	458,930,058.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-275,335,392.38	-348,243,958.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	172,938,840.00	173,918,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-135,389,255.37	-151,549,708.05
393	Биет бус хөрөнгө	48,051,920.00	48,051,920.00
39303	Бусад биет бус хөрөнгө	48,051,920.00	48,051,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,029,219,160.63	869,184,583.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	107,380,092.73	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	107,380,092.73	0.00
413	Өглөг	107,380,092.73	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,949,252.73	0.00
4136	Бусад өглөг	105,430,840.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	105,430,840.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	921,839,067.90	869,184,583.93
51	Засгийн газрын хувь оролцоо	921,839,067.90	869,184,583.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	921,839,067.90	869,184,583.93
51101	Өмч: - төрийн	780,622,551.79	780,622,551.79
512	Хуримтлагдсан үр дүн	-311,993,011.42	-364,647,495.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-297,740,320.60	-311,966,011.42
51220	Тайлант үеийн үр дүн	-14,252,690.82	-52,681,483.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,209,527.53	453,209,527.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,029,219,160.63	869,184,583.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,075,157,316.20	4,442,685,524.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,724,381.20	24,622,000.65
120	Нийтлэг татварын бус орлого	8,724,381.20	24,622,000.65
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,724,381.20	19,618,000.65
120004501	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Хөрөнгө	5,330,899.20	17,138,203.65
120004502	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	3,393,482.00	2,479,797.00
120009	Бусад орлого	0.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,066,432,935.00	4,418,063,524.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,799,143,900.00	3,601,101,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,799,143,900.00	3,601,101,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	267,289,035.00	816,965,824.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,801,250.00	385,713,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,518,625.00	431,248,824.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	173,969,160.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,089,410,007.02	4,495,367,008.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,089,410,007.02	4,495,367,008.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,872,570,585.21	4,377,828,064.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,210,903,616.84	3,070,380,900.94
210101	Үндсэн цалин	1,026,960,251.29	1,284,956,638.40
210102	Нэмэгдэл	420,218,446.92	703,585,512.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	157,985,673.16	208,999,900.00
210104	Урамшуулал	605,739,245.47	872,838,850.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,436,362.20	392,059,992.72
210201	Тэтгэврийн даатгал	196,142,344.41	261,696,808.82
210202	Тэтгэмжийн даатгал	23,449,995.43	22,224,911.98
210203	ҮОМШ өвчний даатгал	18,752,855.44	15,321,838.49
210204	Ажилгүйдлийн даатгал	7,196,088.54	14,759,609.62
210205	Эрүүл мэндийн даатгал	46,895,078.38	78,056,823.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,348,513.13	33,824,012.82
210301	Гэрэл цахилгаан	12,198,998.61	12,429,135.32
210302	Түлш, халаалт	16,615,794.36	17,052,292.12
210303	Цэвэр, бохир ус	3,533,720.16	4,342,585.38
2104	Хангамж, бараа материалын зардал	50,231,573.31	88,869,821.03
210401	Бичиг хэрэг	16,095,383.43	36,950,515.05
210402	Тээвэр, шатахуун	9,890,000.00	29,770,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	10,970,298.05	14,059,507.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,275,891.83	8,089,798.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,433,400.00	3,600,000.00

Нийслэлийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	37,433,400.00	3,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,152,381.99	183,653,961.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,440,499.99	182,885,279.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,552.00	207,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,064,737.74	605,439,375.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,408,160.00	488,880,421.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,341,000.00	12,446,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	102,315,577.74	104,112,954.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	216,839,421.81	117,538,944.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,637,917.00	109,406,143.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,437,917.00	105,446,143.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	3,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,201,504.81	8,132,801.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	290,605,344.81	7,758,277.35
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	374,524.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-14,252,690.82	-52,681,483.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,252,690.82	-52,681,483.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,270,523,775.00	4,423,067,524.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,004,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,004,000.00
120009	Бусад орлого	0.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,270,523,775.00	4,418,063,524.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,799,143,900.00	3,601,101,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,799,143,900.00	3,601,101,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	471,379,875.00	816,965,824.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,801,250.00	385,713,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,518,625.00	431,248,824.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	378,060,000.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,256,473,375.00	4,396,987,924.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,934,230,113.19	4,278,561,632.65
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,227,838,735.32	3,070,947,850.37
210101	Үндсэн цалин	995,702,912.02	1,300,811,106.17
210102	Нэмэгдэл	420,218,446.92	704,437,902.02
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	157,985,673.16	208,999,900.00

Нийслэлийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	653,931,703.22	856,698,942.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,962,624.70	382,162,249.48
210201	Тэтгэврийн даатгал	195,820,202.91	261,836,457.04
210202	Тэтгэмжийн даатгал	23,412,096.43	30,081,448.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,722,536.24	15,321,838.49
210204	Ажилгүйдлийн даатгал	7,188,508.74	14,759,609.62
210205	Эрүүл мэндийн даатгал	46,819,280.38	60,162,896.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,348,513.13	33,824,012.82
210301	Гэрэл, цахилгаан	12,198,998.61	12,477,939.90
210302	Түлш, халаалт	16,615,794.36	16,752,263.92
210303	Цэвэр, бохир ус	3,533,720.16	4,593,809.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,053,698.05	96,997,137.98
210401	Бичиг хэрэг	15,620,000.00	44,750,630.00
210402	Тээвэр, шатахуун	8,480,000.00	34,140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,057,198.05	12,716,507.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,896,500.00	5,390,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,715,400.00	3,600,000.00
210604	Урсгал засвар	38,715,400.00	3,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,511,981.99	189,703,961.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,565,499.99	188,935,279.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,552.00	207,352.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,234,600.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,799,160.00	501,326,421.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,008,160.00	485,845,421.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,791,000.00	15,481,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	322,243,261.81	118,426,291.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,637,917.00	110,293,490.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,437,917.00	106,333,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	3,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	290,605,344.81	8,132,801.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	290,605,344.81	7,758,277.35
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	374,524.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,050,400.00	26,079,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	21,079,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	21,079,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	21,079,600.00
223001	Бусад хөрөнгө	0.00	21,079,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-21,079,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	14,050,400.00	5,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	5,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-297,740,320.60	936,091,758.72
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-297,740,320.60	936,091,758.72
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-14,252,690.82	-14,252,690.82
C08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-311,993,011.42	921,839,067.90
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-311,993,011.42	921,839,067.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	27,000.00	27,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-311,966,011.42	921,866,067.90
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-52,681,483.97	-52,681,483.97
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	780,622,551.79	453,209,527.53	-364,647,495.39	869,184,583.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,601,107,600.00	3,593,343,422.65	7,764,177.35	99.8%
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,492,128,200.00	3,484,369,932.65	7,758,267.35	99.8%
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,988,941,000.00	2,988,940,999.85	0.15	100.0%
210101	Үндсэн цалин	1,300,251,000.00	1,300,211,289.49	39,710.51	100.0%
210102	Нэмэгдэл цалин	704,698,100.00	704,437,902.02	260,197.98	100.0%
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	208,999,900.00	208,999,900.00	0.00	100.0%
210104	Урамшуулал	774,992,000.00	774,992,000.00	0.00	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	369,512,100.00	369,512,100.00	0.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	252,934,500.00	252,934,500.00	0.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	29,144,400.00	29,144,400.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,572,200.00	14,572,200.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	14,572,200.00	14,572,200.00	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	58,288,800.00	58,288,800.00	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,141,500.00	33,824,012.82	7,317,487.18	82.2%
210301	Гэрэл, цахилгаан	15,047,200.00	12,477,939.90	2,569,260.10	82.9%
210302	Түлш, халаалт	21,634,300.00	16,752,263.92	4,882,036.08	77.4%

Нийслэлийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	4,460,000.00	4,593,809.00	-133,809.00	103.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	20,691,600.00	20,397,437.98	294,162.02	98.6%
210401	Бичиг хэрэг	5,600,000.00	5,581,530.00	18,470.00	99.7%
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,491,600.00	11,225,907.98	265,692.02	97.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,390,000.00	10,000.00	99.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,600,000.00	4,580,000.00	20,000.00	99.6%
210602	Тавилга	1,000,000.00	980,000.00	20,000.00	98.0%
210604	Урсгал засвар	3,600,000.00	3,600,000.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,742,000.00	59,634,382.00	107,618.00	99.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,962,000.00	58,865,700.00	96,300.00	99.8%
210803	Даатгалын үйлчилгээ	194,900.00	194,900.00	0.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,600.00	207,352.00	248.00	99.9%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	55,000.00	11,000.00	83.3%
210807	Газрын төлбөр	311,500.00	311,430.00	70.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	7,481,000.00	19,000.00	99.7%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	7,500,000.00	7,481,000.00	19,000.00	99.7%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,979,400.00	108,973,490.00	5,910.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,979,400.00	108,973,490.00	5,910.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	106,339,400.00	106,333,490.00	5,910.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	2,640,000.00	0.00	100.0%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,601,107,600.00	3,593,343,422.65	7,764,177.35	99.8%
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,601,107,600.00	3,593,343,422.65	7,764,177.35	99.8%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	816,965,824.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	816,965,824.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,271,300.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	82,006,850.52
210101	Үндсэн цалин	299,908.34
210104	Урамшуулал	81,706,942.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,650,149.48
210201	Тэтгэврийн даатгал	8,901,957.04
210202	Тэтгэмжийн даатгал	937,048.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	749,638.49

Нийслэлийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	187,409.62
210205	Эрүүл мэндийн даатгал	1,874,096.22
2104	Хангамж, бараа материалын зардал	86,299,300.00
210401	Бичиг хэрэг	48,868,700.00
210402	Тээвэр, шатахуун	32,940,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,490,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,469,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	140,469,579.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	493,845,421.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	485,845,421.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
212	ТАТААС	374,524.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	374,524.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	374,524.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,320,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	816,965,824.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	816,965,824.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	385,713,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	431,248,824.00
120009	Бусад орлого	4,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 33,936.1 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлыг 21,079.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Ахмадын санд төвлөрүүлсэн 5,000.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд үлдэгдлээр тайлагнаагүй;
- НДШ-ийн 7,856.5 мянган төгрөгийн илүү төлөлтийг авлагаар тусгаагүй.

Эдгээр нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 26,520.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 19,581.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 6,939.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 26,520.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,850.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн 19,581.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын орлого, зарлагын 6,939.1 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны бүрдэл дутуу баримтаар хийсэн, тайланг зөрүүтэй тооцоолж гаргасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн эд хариуцагчийн тайланг хянаж, нягтлан бодох бүртгэлд тусгах.

3.2.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 53 нэр төрлийн 97,759.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцсэнгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг ангилан дахин үнэлж бүртгэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлыг дутуу тайлагнасан	1	21,079.6	1	21,079.6	1	21,079.6
Ахмадын санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд үлдэгдлээр тайлагнаагүй.	1	5,000.0	1	5,000.0	1	5,000.0
НДШ-ийн илүү төлөлтийг авлагаар тусгаагүй.	1	7,856.5	1	7,856.5	1	7,856.5
Дүн	3	33,936.1	3	33,936.1	3	33,936.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	19,581.6	1	19,581.6		
Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг анхан шатны бүрдэл дутуу баримтаар хийсэн, тайланг буруу гаргасан.	1	6,939.1			1	6,939.1
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 53 нэр төрлийн 97,759.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.	1	-			1	-
Дүн	3	26,520.7	1	19,581.6	2	6,939.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд их хэмжээний шатахуун нөөцөлсөн.	1	7,440.0	1	7,440.0		
Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/435 дугаар захирамжаар нэмэлт санхүүжилт авч, үндсэн ажил үүргээ гүйцэтгэсэн ажилтнуудад дэмжлэг олгосон.	1	175,977.0			1	175,977.0
Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй.	1	68,682.4			1	68,682.4
Сургалт сурталчилгаатай холбоотой зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй.	1	94,648.0			1	94,648.0
Дүн	4	346,747.4	1	7,440.0	3	339,307.4